# ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ



***МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО***



***ХЯТАДЫН ҮНЭТ ЦААСНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО***

**ҮНЭТ ЦААСНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР**

**БЭЭЖИН**

**24/01/2008**

шаардлагуудыг өөрчлөх эсвэл даван өөрчлөхгүй. Санамж бичиг нь гуравдагч этгээдэд хамаарахгүй.

3. Санамж бичиг нь Талуудын харьяалах улсын хууль, дүрэмд нийцсэн, Талуудын холбогдох нөөц бололцооны хүрээнд байх ба Талуудын харьяалах улсын нийтийн ашиг сонирхолтой харшлаагүй байна.

4. Талууд нь нөгөө талынхаа зохицуулж буй үнэт цаас болон бусад холбогдох бүтээгдэхүүний зах зээлийн хууль, зохицуулалтын шаардлагыг зөрчих эсхүл зөрчиж болох аливаа хамааралтай мэдээллийг олсон бол өөрийн дотоодын хууль, журмын зөвшөөрөх хэмжээгээр нөгөө талдаа өгөх үүрэг гаргана.

## II. ХАМРАХ ХҮРЭЭ

Талууд дор дурдсан хүрээнд хамаарах чиг үүргээ хэрэгжүүлэхэд харилцан дэмжлэг үзүүлэх зорилгоор хамтран ажиллаж мэдээлэл солилцохоор зөвшөөрөв.
Үүнд:

a) үнэт цаас гаргагчид болон үнэт цаас санал болгогчдын зүгээс хөрөнгө оруулагчдад хамаарах мэдээллийг бүрэн дүүрэн үнэн зөвөөр мэдээлүүлэх;

b) үнэт цаас болон бусад хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнийг гаргах, тэдгээрийн талаар зөвлөгөө өгөх, удирдах, байршуулах, тохиролцох зэрэг үйл ажиллагаанд холбоотой хууль тогтоомжийг мөрдүүлэх;

c) үнэт цаас болон бусад хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний зах зээлд ажиллаж байгаа брокер/дилер болон зөвлөгч нарын зохистой байдлыг хангах, эдгээр байгууллага мэргэжилтэнгүүдийн шударга болон зүй зохистой ажиллагааны, өндөр стандарт бүхий үйл ажиллагааг хөгжүүлэх;

d) арилжаа, клиринг төлбөр тооцоо ба бусад үнэт цаас болон хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний зах зээлтэй холбоотой үйл ажиллагааг хянан шалгах ба тэдгээрийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх;

талууд дахин санамж бичигт гарын үсэг зурахгүйгээр харилцан бичгээр урьдчилан мэдэгдэнэ.

## VII. ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛЖ ЭХЛЭХ

Санамж бичиг нь гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

## VIII. ЦУЦЛАХ

Санамж бичгийг цуцлах тухай мэдэгдлийг мэдэгдэл гаргаж буй тал 30 хоногийн өмнө нөгөө талдаа бичгээр өгнө. Энэхүү санамж бичиг цуцлах өдрийг хүртэл аливаа туслалцаа үзүүлэхтэй холбоотой хүсэлтүүд үйлчилсэн хэвээр байна.

Харилцан ойлголцлын тухай санамж бичгийн англи, хятад, монгол хэл дээрх эх хувьд 2008 оны 1 дүгээр сарын 24-ны өдөр БЭЭЖИН хотноо гарын үсэг зурав.

Бүх эх бичвэрүүд адил хүчинтэй бөгөөд ойлголцлын зөрүү гарвал англи хэл дээрх эхийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРООГ
ТӨЛӨӨЛЖ

Д.БАЯРСАЙХАН
Дарга

ХЯТАДЫН ҮНЭТ ЦААСНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООГ
ТӨЛӨӨЛЖ

ШАНГ ФУЛИН
Дарга